



**ТОРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 638

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, 539,756,022.00 (таван зуун гучин есөн сая долоон зуун тавин зургаан мянга хорин хоёр) төгрөгийн балансын үнз бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захирагааны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 967,653,186.00 (есөн зуун жаран долоон сая зургаан зуун тавин турван мянга нэг зуун наян зургаан) төгрөгийн үнз бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захирагааны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захирагааны дарга Д.Батмөнх, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захирагааны даргын албан ўргийт тур орлон гүйцэтгэгч Б.Үндармаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮРП
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002603


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
638. дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГДАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Конторын барилга /2 давхар, зоорьтой, оффис, үйлчилгээний зориулалттай, 212,7 м.кв талбай бүхий/	2017	539,756,022.00
	Дүн	-	539,756,022.00 (таван зуун гучин есөн сая долоон зуун тавин зургаан мянга хорин хоёр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
6.38. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**ХӨВСГӨЛ НУУР-ЭГИЙН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Конторын барилга /2 давхар, оффисын зориулалттай/	2017	967 653 186,00
	Дүн	-	967,653,186.00 (өсөн зуун жаран долоон сая зургаан зуун тавин гурван мянга нэг зуун наян зургаан)